

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга нарын уулзалт семинарыг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж нийт 18 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, 14 сумын нарийн бичгийн дарга нар хамрагдлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн А/06 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, хяналт шалгалтын ажлыг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдамжийн дагуу зохион байгууллаа.

2021 оны 10-р сарын байдлаар 18 сум төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, хяналт шалгалтын ажлын тайлангаа ирүүлж 1 сум өмчийн тайлангаа ирүүлээгүй байна.

Удирдамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүн Ихтамир, Чулуут, Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хотонт, Цэнхэр, Батцэнгэл, Булган, Эрдэнэбулган зэрэг сумдын ажил байдалтай газар дээр нь танилцаж төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл, зөвлөмж хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

“Архангай түншлэл-2021” намрын үзэсгэлэн худалдааг 10 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Эрдэнэбулган суманд зохион байгуулж шилдгүүдээ тодрууллаа. Үүнд: Шилдгийн шилдэг “Гранпри” шагналаар Эрдэнэбулган сумын иргэн С.Адъяасүрэн, Сүү, сүүн бүтээгдэхүүний төрөлд Жаргалант сумын иргэн М.Жаргалсайхан. Мод, модон эдлэлийн төрөлд Булган сумын иргэн Ш.Отгонбаяр, Хүнсний ногоо, жимс жимсгэний төрөлд Эрдэнэбулган сумын иргэн Б.Эрдэнэсүрэн, Гар урлалын төрөлд Тариат сумын иргэн Н.Норовцогзол нар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.

Мөн Гурил, гурилан бүтээгдэхүүний төрөлд Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль, Сав, баглаа боодол, хаяг шошгоор Чулуут сумын иргэн Д.Отгонтуяа, Бэлгийн багцийн шилдгээр Цахир сумын иргэн Д.Чингис нар тэргүүлсэн байна.

Энэ жилийн үзэсгэлэн худалдаанд хамгийн сайн зохион байгуулалтай оролцсон сумдыг шалгаруулснаас Өндөр-Улаан сум 1-р байр, Батцэнгэл сум 2-р байр, Хайрхан сум 3-р байрт тус тус шалгарсан байна.

“Архангай түншлэл-2021” үзэсгэлэн худалдаанд нийт 130 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцож 128.206.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

2021 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, сүүлийн 24 цагт PCR-аар шинжилсэн 140 сорьцноос 26, түргэвчилсэн оношлуурын 117 шинжилгээнээс 49, эмнэлзүйгээр 2, нийт 77 тохиолдол батлагдсан байна. Тодруулбал: Ихтамир-1, Чулуут-3, Хангай-1, □Өндөр-Улаан-2, □Жаргалант-7, □Цэцэрлэг-9, □Хайрхан-2, □Батцэнгэл-2, □Хашаат-7, □Цэнхэр-6, □Булган-1, □Цахир-1, □Тариат-3, □Эрдэнэмандал-1, □Эрдэнэбулган-31.

2021 онд батлагдсан тохиолдол нийт 11197, тусгай эмнэлгүүдээс 80, Өрхийн эмнэлгийн хяналтад гэрээр эмчлүүлэгч 20, Сумдад гэрээр эмчлүүлэгч 7, нийт 107 хүн эдгэрсэн. Нийт 11197 тохиолдлын 10440 буюу 93% нь эдгэрсэн, Нийт нас баралт 35, Эмчлүүлж байгаа 887, үүнээс: 23 тусгай эмнэлэгт – 669, Биеийн байдал Хөнгөн 579, хүндэвтэр 76, хүнд 12, маш хүнд 5. ӨЭМТ-үүдийн хяналтад гэрээр эмчлэгдэж байгаа 127: Ар Мөнгөнчагнуур - 54, Ар Мөнхжин - 37, Ар Манал – 36, Сумдад гэрээр эмчлэгдэж байгаа 91 иргэн байна. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын 2211 иргэн гэрийн тусгаарлалтад байна. Аймгийн хэмжээнд I тунд 60348, II тунд 56388, III тунд 11413 хүнийг дархлаажуулсан байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт

2021 оны орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 153.0 сая төгрөг, аймгийн төсөвт 1130.0 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 6.581.178.1 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 483.809.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн өмчит 30 төсөвт байгууллагад 52.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 10 төсөвт байгууллагад 47.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх, 25 байгууллагад 358 нэр төрлийн 364.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрлийг тус тус олгосон.

2021 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн яамнаас эрх шилжиж ирсэн 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Эрүүл мэндийн төвийн засвар (Архангай, Эрдэнэбулган сум, Хоршоолол баг), ЗГХЭГ-аас эрх шилжиж ирсэн 100.0 сая төгрөгийн Сум, багийн хөгжлийг дэмжих (Архангай) 1 төсөл арга хэмжээ, ЗДТГ-ын төсөвт 150.0 сая төгрөгийн Нутгийн удирдлагын ордоны барилгын өргөтгөл, засварын ажлын зураг төсөв боловсруулах, 179.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Аюулгүй нөөцөд өвс, тэжээл бэлтгэх 1 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сан болон Авто замын сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжих 986.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ, нийт 1365.0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 230.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Өгийнуур сумын Орхон голын Модон гүүрийн засварын ажилд “Эвт уул” ХХК, 130.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Хангай сумын зам засварын ажилд “Авто зам” ХХК, 60.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий улсын чанартай авто замын дагуух ногоон байгууламжийн хамгаалалтын хашаа барих ажилд “Тайгер дизайн” ХХК, 60.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Хог хаягдлаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Хотонт сумаас Солонготын даваа чиглэлийн MR300 маршрутын зам дагуух сум суурин газруудад “Хог түр байршуулах цэг” байгуулах ажилд “Тайгер дизайн” ХХК-уудтай тус тус гэрээ байгуулах эрх олгосон байна.

Санхүүгийн хяналт

Нөхөн төлбөрийн барагдуулалтыг эрчимжүүлэх удирдлагын үүрэг үүрэг чиглэлийн дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэр зөрчсөний улмаас тогтоогдсон нөхөн төлбөрийг барагдуулах арга хэмжээг улсын ахлах байцаагч ахлан аудитор-улсын байцаагч нар хариуцан ажиллаж, хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын төсөв захирагч нарт хандан төлбөрийг хариуцан барагдуулах үүрэг бүхий албан бичиг хүргүүлсний зэрэгцээ 3 байгууллагын 4 албан тушаалтан-хариуцагч нартай холбоотой 101.0 сая төгрөгийн төрд учруулсан хохирлыг барагдуулахаар Архангай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Эрүүл мэндийн байгууллагуудын 2020-2021 оны үйл ажиллагаанд дотоод аудит, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2019-2020 оны үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлууд тайлагналтын үе шат руу орсон. Эрдэнэбулган сумын

Ирээдүй цогцолбор сургуулийн ажилтан албан хаагчдаас ирүүлсэн 2 өргөдлийн дагуу хяналт шалгалт хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт

Аймгийн хэмжээнд 2021 оны 10 дугаар сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 16 удаа гарснаас, объектын гал түймэр 4, объектын гал түймрийн зөрчил 6, хээрийн түймэр 2, хүний гоц халдварт өвчин 1, малын халдварт өвчин 1, эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага 2 удаа тус тус гарсан байна.

2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 21/4155 бүртгэлийн дугаартай шинжилгээний дүнгээр мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин болох нь батлагдан ирсэн тул аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/150 дугаар захирамжаар Ихтамир сумын Эрдэнэтолгой багийн Нарийн өлөнт, Их өлөнт, Их мухарын аманд хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байна.

Дээрх суманд суурин пост 4, хөдөлгөөнт эргүүл 1, аймгийн Цагдаагын газраас 7, Онцгой байдлын газраас 3, сум орон нутгийн дүйцүүлэх цэргийн алба хаагч-4, сумын ЗДТГ-аас 15 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт байршилтай төр захиргааны байгууллагуудын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус зохион байгуулж ажиллалаа.

Шалгалтанд 10 байгууллага хамрагдаж, Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, журам, заавар болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 80 зөрчил илрүүлж, 11 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх 10 албан шаардлагыг байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мөрдүүлэх, хүн хоорондын зай бариулах, амны хаалт тогтмол зүүлгэх, ариутгал, халдваргүйжүүлэлт, агаар сэлгэлт тогтмол хийлгэх, халуун хэмжих, QR код уншуулж бүртгүүлэх талаар Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа Хүнсний дэлгүүрүүд, худалдааны төвүүд болон төрийн байгууллагуудын нийт 1200 гаруй ажилтан, албан хаагч, иргэдэд заавар, зөвлөмжийг өгч, аж ахуйн нэгжийн ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж, иргэд олон нийтийг амны хаалт /маск/ зүүхийг уриалж ажиллаж байна.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж, орон нутгийн хэмжээнд бороо, ус их байгаатай холбогдуулан үер усны ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээ сурвалжлагыг байрлуулж 5044 иргэнд хүрч хандалт авсан байна.

Аймгийн ард иргэдийг бодит үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын вэб сайтаас мэдээг авч олон нийтийн хэрэгслээр түгээж байна.

2021 оны 10-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 326 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 103, хулгайлах гэмт хэрэг 93, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 32, малын хулгайн гэмт

хэрэг 41, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 23, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 86, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 26, гэмт хэргийн илрүүлэлт 49.4 хувьтай байна.

Нийт 16588 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 15876 иргэнд 603198.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 2280.6 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 20.7 хувьтай байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2021 оны 09 сараас төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 16 суманд 20 хяналтын чиглэлээр 176 объектыг шалгалтанд хамруулаад байна. 12 цагаар хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэж АОК-ын Шуурхай штабын бүрэлдэхүүнд 4 албан хаагч бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Цар тахалтай холбоотойгоор Засгийн газар, УОК, АОК-оос гаргасан тогтоол, шийдвэр, журам, МХЕГ-ын даргаас өгсөн үүрэг чиглэл, урьдчилан сэргийлэх шалгалтын удирдамж, аймгийн Засаг даргын захирамжийн холбогдох заалтыг чиг үүргийн дагуу хангуулан ажиллаж байна.

Худалдаа, үйлчилгээний газрууд, үсчний салон, халуун усны газар, бүх шатны боловсролын байгууллага зэрэг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын халдваргүйтгэлийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, халдвар хамгааллын дэглэмийн байдалд байнгын хяналт хийж байна.

Хяналт шалгалтын явцад гарч байгаа нийт зөрчлийн 58.0 хувийг 2 цаг тутам цэвэрлэгээ, үйлчилгээ хийж бүртгэл хөтөлдөггүй, 78 хувийг хүн хоорондын зай барих, тэмдэг тэмдэглэгээгүй, үйлчлүүлэгчийн халуун хэмжээгүй, QR кодыг байршуулаагүй, өдөр тутам дотоод цэвэрлэгээ, ариутгалыг хийж хэвшүүлээгүй, ажилтан, албан хаагчдын биеийн дулааныг хэмжих бүртгэл хөтлөөгүй зэрэг зөрчил эзэлж байна. Мөн аж ахуй нэгж, байгууллага гадна орчныхоо 50 м хүртэлх газрын хог хаягдлыг, /өвлийн улиралд цас мөсийг/ цэвэрлэдэггүй зөрчил нийт зөрчлийн 20%-ийг эзэлж байна.

“Сэншивэе Монгол ХХК”, “Батдөлгөөн мөрөн ХХК”, “Гурван хайрханы асар ХХК” нь уурхайд байх бичиг баримтын бүрдэлийг хангаагүй, хаягдал усны далан хаалтыг бэхжүүлэх арга хэмжээ аваагүйгээс олон хоног үргэлжлэн орсон устай бороонд далангууд задарч үйлдвэрлэлд ашиглагдсан бохир ус голтой нийлж ус бохирдуулж байгаа, “Сэншивэе Монгол ХХК” нь 2019 онд ашиглалт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийгээгүй зэрэг холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн зөрчил илэрсэн байна.

Иймд улсын байцаагчийн 4-6 заалт бүхий 03-05-017/30 дугаар албан шаардлагыг “БМНС ХХК”-д, 03-05-017/31 дугаар албан шаардлагыг “Бат дөлгөөн мөрөн ХХК”-д, 03-05-017/32 дугаар албан шаардлагыг “Сэншивэе Монгол ХХК”-д, 03-05-017/33 дугаар албан шаардлагыг “Гурван хайрханы асар ХХК”-д, 03-05-017/34 дугаар албан шаардлагыг “Эрдэнэсийн хотхон ХХК”-д өгч үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

“БМНС” ХХК нь Өлийн голын хэсгийн ашиглалтын блокт хөрс хуулалтын ажил гүйцэтгэн алт олборлолтын ажлыг эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 8 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийгээд байна.

“Сэншивэе монгол ХХК” нь 2018 онд алт олборлолтын улмаас үүссэн 25 метр гүнтэй 1 га талбайтай карьерын усыг соруулан нөхөн дүүргэлт буюу нөхөн сэргээлтийн ажил, “Батдөлгөөн мөрөн ХХК” нь ус цэвэршүүлэх 3 даланг сэргээн засварлах, эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж эхэлсэн байна.

“Гурван хайрханы асар ХХК” нь MV-004174 дугаар тусгай зөвшөөрлийн талбайд 4 экскаватор, 5 автосамосвал, 2 ковш зэрэг нийт 11 техник хэрэгслийг талбайд оруулж техникийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлсэн байна.

Тусгай зөвшөөрөл сэргэсэн боловч “Сэншивэе Монгол” ХХК, “Батдөлгөөн мөрөн” ХХК, “Гурван хайрханы асар” ХХК-иуд нь Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан уул уурхайн олборлолт явуулахад шаардагдах бичиг баримтын бүрдлийг хангаагүй тул дээрх аж ахуй нэгжүүд нь тусгай зөвшөөрөл бүхий талбайдаа зөвхөн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэх нь

зөвшөөрөгдөж байгаа ба хөрс хуулах, алт олборлох зэрэг бусад хууль бус үйл ажиллагаанд Цэнхэр сумын Орхон багт “Хяналтын пост”-нд улсын байцаагч нар хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн Цагдаагийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Мэргэжлийн хяналтын газар хамтран Эрдэнэбулган сумын иргэд түлшний модны хүрэлцээ хангамж дутагдалтай байгаа тул аймгийн төвийн ойролцоох Булган, Ихтамир сумдын ойн нөхөрлөлүүдээс түлшний модны хүргэлтийг зохион байгуулж байгаа байдалд хяналт тавьж ажиллаж байна.

Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд өрх, иргэдийг хамруулсан байдал, зарцуулсан хөрөнгө, үр дүнд урьдчилан сэргийлэх шалгалтын хүрээнд гурав болон түүнээс дээш гишүүн ам бүлийн тооноос хасагдсан, хүнсний эрхийн бичгийг 4 сарын хугацаанд аваагүй болон ашиглаагүй зэрэг зөрчилд улсын байцаагчийн 1336000 төгрөгийн акт тогтоон барагдууллаа.

Мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдсэн лаборатори нь 2021 оны 10 сарын байдлаар 1197 сорьцонд 5263 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Үүнээс 172 үзүүлэлт нь стандартын шаардлага хангаагүй байгаа нь нийт сорьцын 3.26%-ийг эзэлж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/545 дугаар захирамжаар Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн байсан хугацаа 10 сарын 01-ний өдөр дуусч хичээл сургалтын үйл ажиллагаа танхимын болон цахим хосолсон хэлбэрт шилжин хэвийн явагдаж байна. 2021-2022 оны хичээлийн жилд Төрийн өмчийн 30, хувийн өмчийн 3 ерөнхий боловсролын сургууль, төрийн өмчийн 35, хувийн өмчийн 1 цэцэрлэг үйл ажиллагаа явуулахаар Боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэлтэй байна.

Жил бүрийн намар гардаг боловсролын салбарын статистик мэдээллийг 33 ерөнхий боловсролын сургууль, 36 цэцэрлэгийн хүрээнд нэгтгэн эхний байдлаар Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлэв.

2021-2022 оны хичээлийн жилд Архангай аймагт 33 ерөнхий боловсролын сургуульд 19031 сурагч суралцаж байна. Энэ нь өмнө хичээлийн жилээс 300 орчим сурагчаар нэмэгдсэн үзүүлэлт юм. Энэ хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангид 1947 сурагч элсэн орлоо.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн “Төлөвлөгөө хэрэгжүүлэх тухай” А/240 дүгээр тушаалын 2 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын үнэлгээний төвөөс “Сургуульд суурилсан үнэлгээ”-г 2021 оны 10-р сарын 13-наас 27-ны өдрүүдэд улс орон даяар зохион байгууллаа. Сургуульд суурилсан үнэлгээний зорилго нь Ерөнхий боловсролын сургууль өөрийн сурагчдын гарааны түвшинг тогтоож, сурагчдын даалгаврын гүйцэтгэл дээр дүн шинжилгээ хийх, цаашдын сургалтын ахиц амжилтыг оношлох зорилготой юм. Уг үнэлгээнд 2-12-р ангийн бүх сурагчид, бүх судлагдхууны чиглэлээр хамрагдлаа.

Соёл

Аймгийн Нийтийн номын сан “Covid-19” цар тахлын үед уншлагын танхимын 30 хувийн дүүргэлттэй халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөн танхимын үйлчилгээ хүргэн ажиллаж байна. Нийтийн уншлагын танхимаар 51 ирэгсэдэд 103 ном, 262 сонин сэтгүүл, Хүүхдийн уншлагын танхимаар 10 уншигч шинээр бүртгэж, 112 ирэгсэдэд 179 ном, гэрээр ном олголтоор 15 уншигч шинээр бүртгэж, 40 ирэгсэдэд 62 ном олгож тус тус үйлчилсэн байна. Номын сангийн MonKoha үүлэн технологийн программд ном шивэх ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд үндсэн фондын 176 нэрийн 1169 ширхэг номыг шивж, бар коджууллаа.

Монгол Улсад орчин цагийн номын сан үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Номын баяр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, орон нутагт ном унших хөдөлгөөн өрнүүлэх, зохиолч уншигчдын уулзалт ярилцлага зохион байгуулах, номын өв санг баяжуулах, хүүхэд залуучуудын ном унших хүсэл сонирхлыг хөхиүлэн дэмжих, сурталчилан таниулах, эх оронч үэл санааг төлөвшүүлэх зорилготой “Номын баяр-2021” арга хэмжээний хүрээнд “Номын сан-Миний амьдралд” эсээ бичлэгийн уралдааныг 2 насны ангиллаар, “Миний хайртай үлгэрийн баатар” гар зургийн уралдааныг 1 насны ангиллаар тус бүр зохион байгуулж, гар зургийн уралдаанд 60 бүтээл, эсээ бичлэгийн уралдаанд нийт 64 материал хүлээн авч, шалгаруулалтыг зохион байгуулж, шилдгүүдийг тодрууллаа.

Аймгийн Хөгжимт драмын театр UBS телевизэд “Хангайн нутгийн дуулал” бүрэн хэмжээний шинэ уран бүтээлийн концерт, МҮОНРТ-д “Арын сайхан хангай” бүрэн хэмжээний шинэ уран бүтээлийн концертыг тус тус үзэгчдийн хүртээл болгохоор бичүүлж, нийт 34 уран бүтээлч оролцсон байна.

Эрүүл мэнд

2021 оны 10 дугаар сарын байдлаар 4334 хүнийг PCR шинжилгээнд, 3925 хүнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулан коронавируст халдварын 2511 батлагдсан тохиолдлыг илрүүлж, эмчилгээнд хамруулсан.

Батлагдсан тохиолдлуудын тандалт судалгааг хийж, 4466 хавьтлыг тогтоож, гэрийн тусгаарлалтад авч, хянасан.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийт 23 дархлаажуулалтын цэгт коронавирусийн эсрэг нэмэлт вакцинжуулалтыг тасралтгүй зохин байгуулан ажиллав. Нэмэлт вакцинжуулалтаар 1-р тунд 71 хүн, 2-р тунд 215хүн, 3-р тунд 2957 хүн тус тус хамрагдсан.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад “Коронавируст халдварын үед цахим сурталчилгаа хийх арга зүй” сэдэвт 16 цагийн сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 22 нийгмийн эрүүл мэндийн ажилтанг хамруулсан

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 4,5 сая төгрөгийн өртөг бүхий өвчтөний монитор мөн бүх сумдын эрүүл мэндийн төвүүдэд 9 сая төгрөгийн өртөг бүхий эх барихын багц хэрэгсэл тус тус шийдвэрлэгдсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хайрхан сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрч байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссын газар дээр ажилласан.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үеийн тусламж үйлчилгээнд дайчлагдан ажиллаж буй аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт ажилчдад сэтгэл зүйч нарын баг 6 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 120 гаруй хүнийг хамруулсан.

"Эрүүл мэндийн нийгмийн хамгааллын хөтөлбөр" халдвар сэргийлэлтийн хяналтын үзүүлэлтийг ЭМХТ-д хүргүүлсэн. Судалгаанаас харахад эмнэлгийн ажилчдын 862 буюу 68.6 хувь нь 1,2 –р тун, 529 буюу 42.1 хувь нь 3-р тундаа хамрагдсан байна. нийт ажилчдын 27.1 хувь буюу 341 ажилтан КОВИД -19 халдвараар өвчилсөн, 17 ажилтан давтан халдвар авсан байна.

Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй 886 ажилтанд 334.6 сая төгрөгний урамшуулал олгосон.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2021 оны 10-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1118 иргэн бүртгэлтэй байгаагаас 537 эмэгтэй. Шинэ ажлын байр 783 үүнээс байнгын ажлын байр 384, улирлын ажлын байр 194, түр ажлын байр 205 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 676, зуучлал 647 байна. Тухайн сарын 19-ны байдлаар 287 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 14, бага- 51, суурь-211, бүрэн дунд- 608, техникийн болон

мэргэжлийн анхан шатны – 21, тусгай мэргэжлийн дунд- 30, Дипломын бакалаврын-183 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 13 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч ЭМНДХэлтэс рүү хүргүүлсэн.

Швейцарын хөгжлийн агентлагын санхүүжилтээр Архангай аймгийн ХХҮГ-ын дэргэд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвтэй боллоо. Энэхүү төв нээгдсэнээр залуучууд чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөж өөрсдийгөө хөгжүүлэх бүрэн боломжтой орчин бүрдэж байгаа юм.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд өрх толгойлсон эмэгтэйчүүдэд органик бүтээгдэхүүний гар урлалын сургалт зохион байгуулж 25 эмэгтэй хамрагдаж, төрөл бүрийн органик саван, лаа, үнэртүүлэгч, ванны бөмбөлөг, ванны давс хийж сурч, өөрийгөө хөгжүүлж, стресс менежментээ зөв удирдан, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлж, органик хэрэглээг амьдралдаа хэвшүүлэн цаашид бизнес болгон орон нутагт брэнд үүсгэх боломжтой боллоо.

Шинэчлэгдэн батлагдсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын дагуу НӨАТ-ын баримт олгодог аж ахуй нэгж, зах, бөөний төвд худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр нь олон улсын стандарт код GS1-13 зураасан кодоор хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 2021 оны 10-р сараас эхлэн олгож байна. Үйлчилгээг үзүүлэхээр 38 хүнсний дэлгүүрийн програм хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2021 оныг “Эерэг хандлага-цахим үйлчилгээний хөгжүүлэлтийн жил” болгон зарлаж хэлтсийн даргын 2021 оны А/21 дүгээр тушаалаар хийгдэх ажлын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шимтгэл төлж байгаа болон өмнө нь шимтгэл төлсөн бүх даатгуулагчдын “Нийгмийн даатгалын дэвтэр”-ийг цахимаар үүсгэсний үр дүнд “Нийгмийн даатгалын ” Гар утасны аппликейшнийг ашиглан иргэд, даатгуулагч шимтгэл төлөлтөө цахимаар харж, цахим “Нийгмийн даатгалын дэвтэр”-ийг “Даатгуулагчид зориулсан вэб”-д байршуулснаар иргэд, даатгуулагч хэвлэн авах боломжийг бүрдүүлсэн.

2021 оны 10-р сарын байдлаар нийт 16553 тэтгэвэр, тэтгэмж авагчдад 49,4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн хугацаанд шуурхай олгож ажилласан байна.

“Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх”- аяныг 2021 оны 07-р сарын 05-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай зохион байгуулан ажиллаж аяны хүрээнд шинээр сайн дурын даатгалд 285 даатгуулагчийг хамруулаад байна.

“Малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх арга зам” сэдэвт уралдааныг Нийгмийн даатгалын хэлтэс, 18 сумын байцаагч, ажилтан, сум багийн Засаг дарга нарын дунд зохион байгуулан ажиллаж байна

Гар утасны аппликэйшнийг 1034 даатгуулагч, иргэдийн гар утсанд суулган баталгаажуулж өгсөн. CALL center үйлчилгээ буюу 7507-9000 дугаараас 2021 оны 01 сарын 01 -аас 2021 оны 10 дүгээр сарын 25-ны байдлаар 8457 даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

“Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл” хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 221 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх тухай” 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн тухай 01 дүгээр хамтарсан албан даалгавар, аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар албан даалгаврын хүрээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай төлөвлөгөөг гарган сумдын Засаг дарга нар, албан байгууллагын удирдлагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, өвөлжилтийн бэлтгэх ханах ажил аймгийн хэмжээнд **88.5** хувьтай хангасан байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын мэдээг 7 хоног бүр авч, холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлж, тодорхой үнэлэлт дүгнэлт хийж, 2-3 удаа ажил эрчимжүүлэх албан бичиг зөвлөмж чиглэлийг сумдын Засаг дарга болон албан байгууллагуудад хүргүүлэн үүрэг даалгавар өгч ажилласан.

Аймгийн 19 сумын 101 багийн 3.7 сая га бэлчээрт 8207 хот айлд 17.1 мянган малчин болон мал бүхий өрхийн 5862.0 сая орчим толгой малыг өвөлжүүлж, хаваржуулах бэлтгэл ажлыг хангалаа.

Бэлчээрийн даацыг аймгийн нийт нутгаар тооцоолж гаргасан дүнгээс (Бэлчээрийн даацын зураг, 2021 оны 8 дугаар сарын 27-нд УЦУОСМХ-д боловсруулав) үзвэл нутгийн 19,2 хувь нь бэлчээр нөөцтэй, 33,7 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 45,5 хувь нь бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 1,4 хувь нь бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрсэн, 0,2 хувь нь бэлчээрийн даац олон дахин хэтэрч гарсан байна.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран 2021 онд бэлчээрийн төлөв байдлыг фото мониторингийн аргаар тодорхойлох ажлыг 355 цэгт судалгаа хийж бэлчээрийн даац хүрэлцээ хангамжийг тогтооход аймгийн хэмжээнд дунджаар 1-3 дахин хэтэрч, ургамлын зүйлийн бүрэлдэхүүн цөөрсөн зэрэг судалгаа гарсан байна.

Мөн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн бэлчээрийн бодит ургацыг тогтоосон дүнгээр өвөл хаврын бэлчээрийн ургац га-д 6.0 цн дундажтай байна.

Аймгийн хэмжээнд нийт 229.2 мянган га отрын бэлчээрийг сумдын иргэдийн Төлөөлөгчдын Хурлын тогтоолоор баталсан боловч бэлчээрийн даац ачаалал ихэнх сумдад 1-3 дахин хэтэрсэн учраас зориулалтын дагуу ашиглах асуудал хүндрэлтэй байна.

Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг Хангай, Батцэнгэл, Өгийнуур, Хашаат сумдын 14 багийн 15000 га бэлчээрт зохион байгуулж нийт 443 малчид, 17 иргэн, 78 төрийн албан хаагч, 78 машин, 52 мотоцикль техник хэрэгсэлтэйгээр ажлыг 81 хувийн үр дүнтэй зохион байгуулсан байна. Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой энгийн механик, биологийн аргаар 25,2 мянган га талбайд тэмцэх ажиллагааг 10 дугаар сарын 11-нээс 11 дүгээр сарын 15-ны хооронд зохион байгуулж байна. Үүнд: Хашаат 8000 га, Цэцэрлэг 8000 га, Өлзийт 4600 га, Өгийнуур 4600 га

Аймгийн хэмжээнд нийт 1179 бэлчээрийн худаг байна. Үүнээс инженерийн хийцтэй гүн өрмийн 1076 худаг, энгийн уурхайн 100 худаг, 3 усан сан байгаа бөгөөд ашиглагдаж байгаа 978 худаг буюу нийт худгийн 97.0 хувийг ашиглаж, Нийт өрхийн буюу 95.0 хувь нь усаар хангагдсан байна.

Хөдөөгийн хүн ам, мал сүргийг усаар хангах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд аймгийн хэмжээнд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, гадаадын төсөл хөтөлбөр болон малчдын хөрөнгөөр 45 инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг шинээр гаргаж ашиглалтад оруулж 670 гаруй өрхийн 67.5 гаруй мянган толгой мал, 157.5 мянган га бэлчээрийг усжуулсан байна.

Үзлэг ангилалтыг 2021 оны 9 дүгээр 15-наас 10 дүгээр сарын 30-ныг хүртэлх хугацаанд гэрээ байгуулсан мал үржүүлэг технологийн аж ахуй нэгж, сумдын ЗДТГазар, сумын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулж 5 сумын нийт 132 малчин өрхийн 12000 толгой үржлийн малыг үзлэг ангилалтанд хамруулж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран Онцгой байдлын үед мал амьтныг эрсдэлээс хамгаалахад баримтлах стандарт зааварчилгаа LEGS сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 110 гаруй мэргэжилтэн оролцсон. Мөн даатгалын байгууллагатай хамтран 1215 өрхийн 165.5 мянган толгой малыг даатгалд хамруулсан урьдчилсан тоо гарч байна.

Энэ онд нэмэгдэл тэжээлд 1061.5 мянган толгой мал орж, байран маллагаанд 131.4 мянган толгой мал өвөлжинө.

Аймгийн хэмжээнд 14.3 мянган ширхэг бодын хашаа, 18.7 мянган ширхэг богийн хашаа нийт 33.0 мянган ширхэг малын хашаа шаардлагатайгаас 31.0 мянган ширхэг

малын хашаа буюу 94.0 хувийн хангамжтай байна. Энэ онд 242 ширхэг бодын хашаа, 290 ширхэг хашааг шинээр барьж ашиглалтад оруулсан.

Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт Чулуут Булган, Цэнхэр сумдын 246 өрхийн 94.1 мянган толгой мал өвөлжинө. Жаргалант, Хашаат, Тариат, Батцэнгэл сумдын 113 өрхийн 39.8 мянган толгой өөрийн аймгийн бусад сумдын нутагт тус тус отроор өвөлжиж, хаваржина. Хашаат сумын 7 өрхийн 7864 толгой мал Булган аймгийн Могод, Гурванбулаг сумдад отроор өвөлжиж, хаваржина.

Малчдын түвшинд 80 мянган тн өвс, 1300 тн гар бэлтгэхээс өнөөдрийн байдлаар 71.2 мянган тн өвс, 100 тн сүрэл, 3484 тн ногоон тэжээл, 54 тн үйлдвэрийн тэжээл, 1183 тн гар тэжээл, 517 тн давс, хужир шүүг бэлтгэн хадлан бэлтгэл 98,8 хувьтай байна. Аймаг сумын аюулгүйн нөөцөд 2950 тн өвс, 1100 тн тэжээл, 400 тн ногоон тэжээл бэлтгэхээс 1539.4 тн өвс, 1151.2 тн ногоон тэжээл, гар тэжээл бэлтгэн бэлтгэл аюулгүй нөөц бэлтгэл аймгийн хувьд 81 хувьтай байна.

Газар тариалан

2021 онд үр тариа 8703 га талбайд үүнээс улаан буудай 8403 га- д, арвай 100 га- д, овьёос 200 га-д, малын тэжээл 3300 га-д, тосны таримал 900 га-д, төмс 277.5 га-д, хүнсний ногоо 147 га-д, жимс жимсгэнэ 168.9 га-д нийт 13496.1 га талбайд тариалахаар төлөвлөж, улаан буудай 9818 га-д, арвай 40.5 га-д, овьёос 241.9 га-д, тосны таримал 420 га-д, малын тэжээл 4732 га-д, төмс 280 га-д, хүнсний ногоо 160 га-д, жимс жимсгэнэ 83 га-д нийт 15977 га талбайд тариалалт хийж тариалалтыг 111.9 хувиар биелүүлсэн.

Үр тарианы ургамлын тариалалтын чанарыг соёололтоор хүлээн авсан дүнгийн нэгтгэлийг авч үзвэл 10400 га талбайд тариалснаас 2307 га буюу 22,8% нь соёололт онц, 5830 га буюу 57,7% нь сайн, 1963,4 га буюу 19,4% нь дунд зэргийн байсан бөгөөд үр тарианы соёололтын үед хур тунадасны хэмжээ багасаж байсан бол сүүлийн өдрүүдэд үргэлжилсэн зөөлөн бороо орсноор хөрсний чийг сайжирч, ургамлын өсөлт хөгжилтөд сайнаар нөлөөлсөн.

Архангай аймаг 2021 оны 10 дугаар сарын 20-ны байдлаар Улаанбуудай 8100 га талбайгаас 14200 тн, арвай 40 га-аас 30 тн, овьёос 50 га-аас 50 тн, тосны ургамлын хураалт хараахан эхлээгүй, малын тэжээл 3370 га-аас 8118 тн, төмс 280 га талбайгаас 2205 тн, хүнсний ногоо 160 га талбайгаас 1280 тн хурааж ургац хураалт 80 хувьтай явагдаж байна.

Гурилын үйлдвэрүүд улаанбуудай авахгүй, ХААДСан үрийн буудайг аж ахуйн нэгжээс авах захиалга өгсөн боловч агуулах сав дүүрсэн гээд шийдтэй хариу өгөхгүй байгаа учраас зарим аж ахуйн нэгж хүлээлтийн байдалтай, хураалтаа хийж чадахгүй байна.

Ургац хураалтанд комбайн-1, хадагч-12, будаа цэвэрлэгч-2, үр сортлогч-5, будаа ачигч-7, төмсний комбайн-1, төмс сортлогч-1, төмс ухагч-8 зэрэг 8 нэр төрлийн 50 техник хэрэгсэл, 218 хүн хүч ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Барилга, дэд бүтэц, газар

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилгуудад 2021 оны 10 дугаар сард барилгын мэргэжилтэн, захиалагч инженерүүд хяналтын хийсэн ажлын тайланг танилцуулан ажил удаашралтай байгаа Хашаат, Өлзийт сумын сургуулийн барилга угсралтын ажилд 3 удаа хяналт хийж ажил сайжруулах үүрэг даалгавар өглөө. Жаргалант сумын сургуулийн барилгын засвар, Эрдэнэбулган сумын 6-р Цэцэрлэгийн засварын ажилд аймгийн Засаг даргын 2021 оны 10-р сарын 05-ны өдрийн А/629 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хяналт тавин ажил сайруулах үүрэг даалгавар өгч ажиллалаа.

2021 оны 10 дугаар сарын 13-15-ны өдрийн хооронд Эрдэнэмандал сум, Хашаат, Өлзийт сумдад баригдаж байгаа барилгуудад үе шатны хяналтаар ажиллаж бетоныг үл

эвдэх аргаар багана дам нуруу, сууринд багажаар хэмжилт хийв.Энэ сард 8 аж ахуйн нэгж иргэнээс 23 шинжилгээ хийж үр дүнг болосрууллаа.

Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ

Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд “Ажлын байрыг дэмжих” зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байна. Үүнд:

- “Хаан” банк 117 иргэн, аж ахуйн нэгжид 7,4 тэрбум төгрөг,
- “Төрийн” банк 46 иргэн, аж ахуйн нэгжид 9.0 тэрбум төгрөг,
- “Хас” банк 21 иргэн, аж ахуйн нэгжид 1.2 тэрбум төгрөг,
- “Голомт” банк 20 иргэн, аж ахуйн нэгжид 1,4 тэрбум төгрөгийн зээлүүдийг тус тус олгосон.

Ажлын байрыг дэмжих зээлийг 353 иргэнд 11,7 тэрбум төгрөг, 64 аж ахуйн нэгжид 9,7 тэрбум төгрөг, нийт 417 иргэн, аж ахуйн нэгжид 21,4 тэрбум төгрөгийн зээл олгож 823 ажлын байрыг хадгалсан байна.

Хөдөө аж ахуйг дэмжих зээлийг олгож эхлээд байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 1161 малчинд 14,2 тэрбум төгрөг, газар тариалангийн чиглэлээр 3 иргэн, аж ахуйн нэгжид 160.0 сая төгрөгийн зээл тус тус олгоод байна.

2020 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт жилийн эцсийн байдлаар 700.8 сая төгрөг орж ирсэн бол 2021 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт энэ оны эхний хагас жилийн байдлаар 989,3 сая төгрөг орж ирсэн байна. 2020 онд сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийг Цэнхэр, Хангай, Өндөр-Улаан сумын 65 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд 240.0 сая төгрөгийн зээл олгож 98 ажлын байр бий болсон байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----